



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/15/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар  
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
Утас: 70432545  
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn  
Ахлах аудитор: Erdenetsetsegd@audit.gov.mn  
Утас: 70432545  
Цахим хаяг: Khovd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (мянган төгрөг) .....	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (мянган төгрөг) .....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр) .....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр) .....	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр) .....	13
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр) .....	15
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	20
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	22
4.1 Ерөнхий зүйл .....	22
4.2 Материаллаг байдал .....	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	23
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	23
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	24
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	27

## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ӨХЗ	Өмч хамгаалах зөвлөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуун тооцоот үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ГХУСЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ЦЭЦЭГ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Б.ГАНБАЯР ТАНАА

2022.03.25 № 02/22  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

## Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цэцэг сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэг сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зардлын зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй урсгал зардалд зарцуулсан, хөрөнгийн бүртгэл ашиглалт, хамгаалалт хангалтгүй, хөрөнгийн тооллого хийгээгүй, жолоочийн тооцоо бодож замын хуудас баталгаажуулаагүй, төсвөөс үр ашиггүй тэвчиж болох зардлуудад хөрөнгө гаргасан, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй зориулалт бус зарцуулж байгаа зэрэг 455.3 сая төгрөгийн зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Асуудлыг онцолсон хэсэг

Нийт орлого 1622.6 сая төгрөг орж 326.9 сая төгрөгөөр давж биелсэн байна. Малын хөлийн татвар 29.6 сая, үл хөдлөх хөрөнгийн татвар 11.9 сая, ан амьтны нөөц ашигласны татвар 108.1 сая төгрөгөөр тасарч, цалин хөлс, ашгийн татвар 96.5 сая, хүн амын орлогын албан татвар 65.4 сая төгрөгөөр давж биелсэн байна.

## Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ нь Хөшөөт хөгжил сангийн санхүүжилтээр 400м талбайн дугуйн зам, гэрэлтүүлэг хийх 250.0 сая, Хөшөөт багийн төвд фитнес төв тохижуулах 30.0

021020180

сая, ОНХС-ийн санхүүжилтээр Цэцэг нуур багийн төвд хөл бөмбөгийн тайлбай байгуулах ажилд 100.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь нийтийн эрх ашигт нийцсэн үр дүнтэй ажил болсон байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Өмнөх онуудад төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн санхүүгийн тайлангийн тогтмол зардлаас бусад үзүүлэлтүүд системийн дээд байгууллагын тайланд нэгтгэгдэх бодлогын өөрчлөлт бий болсонтой холбоотойгоор эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөл бүхий өөрчлөлтүүд орсон байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,436,571.8	1,675,094.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	794,809.6	993,392.7
33	АВЛАГА	410,901.4	631,364.6
35	БАРАА МАТЕРИАЛ	230,860.8	50,337.5
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	12,691,088.7	7,393,773.1
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12,691,088.7	7,393,773.1
39200	Биет хөрөнгө	12,614,137.3	7,388,572.0
39300	Биет бус хөрөнгө	76,951.5	5,201.1
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	14,127,660.6	9,068,867.9
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	28,853.3	41,441.7
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	28,853.3	41,441.7
41300	Өглөг	28,853.3	41,441.7
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	14,098,807.2	9,027,426.20
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	14,098,807.2	9,027,426.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,079,824.1	856,592.6
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	9,922,513.0	7,935,879.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,096,470.2	276,395.4
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	14,127,660.6	9,068,867.9

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

/мянган.төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	8,125,056.50	2,493,827.10
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	463,450.60	631,379.60
110	Орлогын албан татвар	55,182.30	256,281.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	55,182.30	256,281.20
113	Хөрөнгийн албан татвар	37,132.60	23,132.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	371,135.70	351,966.00
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	3,838,782.40	1,392,455.20
120	Нийтлэг татварын бус орлого	3,835,194.40	1,384,388.10
121	Хөрөнгийн орлого	3,588.00	8,067.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	3,822,823.40	469,992.30
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	5,042,157.50	1,933,475.20
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	4,907,041.30	1,933,475.20
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,755,745.80	1,908,638.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,782,905.40	335,020.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	235,532.60	46,676.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	257,538.80	440,722.40
2104	Хангамж, бараа материалын зардал	577,453.20	632,537.30

2105	Нормативт зардал	221,633.50	335.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,063.20	4,721.10
2107	Томилолт, зочны зардал	8,043.00	5,456.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,559.60	7,049.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	614,016.70	436,118.80
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,151,295.50	24,837.10
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	135,116.20	-
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	3,082,899.00	560,351.90
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	3,015.70	5,570,536.00
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	3,079,883.30	(5,010,184.10)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

/мянган.төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	3,747,720.60	2,188,641.50
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	463,450.60	631,379.60
110	Орлогын албан татвар	55,182.30	256,281.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	55,182.30	256,281.20
113	Хөрөнгийн албан татвар	37,132.60	23,132.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	371,135.70	351,966.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	55,409.30	62,444.50
1181	Газрын төлбөр	3,519.40	10,853.20
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	312,207.10	278,668.20
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	499,139.10	1,087,269.60
120	Нийтлэг татварын бус орлого	495,551.10	1,079,202.60
121	Хөрөнгийн орлого	3,588.00	8,067.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	2,785,130.90	469,992.30
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,991,897.40	1,119,330.90
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,991,897.40	1,119,330.90
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,795,035.40	1,024,962.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,795,028.70	360,161.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	232,560.00	49,798.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	292,804.30	474,471.00
2104	Хангамж, бараа материалын зардал	87,742.40	37,577.70
2105	Нормативт зардал	227,647.70	335.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,074.30	4,721.10
2107	Томилолт, зочны зардал	8,043.00	5,456.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,432.30	8,116.70
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	111,702.70	84,323.90
211	<b>ХҮҮ</b>	-	-
212	<b>ТАТААС</b>	-	-

213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	196,862.00	94,368.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	755,823.20	1,069,310.70
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	564,756.20	870,627.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	564,756.20	870,627.60
2200	Дотоод эх үүсвэрээр	564,756.20	870,627.60
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	(564,756.20)	(870,627.60)
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	(13,200.00)	(100.00)
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	13,200.00	100.00
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	177,867.00	198,583.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	616,942.60	794,809.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	794,809.60	993,392.70

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

/мянган.төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	11,061,331.30	11,061,331.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(42,407.40)	(42,407.40)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,018,924.00	11,018,924.00
9	Тайлант үеийн үр дүн	3,079,883.30	3,079,883.30
10	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	14,098,807.20	14,098,807.20
11	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	14,098,807.20	14,098,807.20
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(55,675.40)	(55,675.40)
13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	14,043,131.80	14,043,131.80
19	Тайлант үеийн үр дүн	(5,010,184.10)	(5,010,184.10)
20	<b>2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	9,032,947.70	9,032,947.70

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

/мянган.төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,406,420.90	1,877,583.31

21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,151,392.30	1,006,855.70
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	987,596.00	912,487.30
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	384,200.40	335,020.30
210101	Үндсэн цалин	242,556.00	221,285.50
210102	Нэмэгдэл	54,850.10	54,663.20
210104	Урамшуулал	8,854.50	6,073.80
210105	Гэрээт ажлын хөлс	77,939.80	52,997.70
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	48,018.90	46,676.60
210201	Тэтгэврийн даатгал	32,657.10	31,740.20
210202	Тэтгэмжийн даатгал	3,707.00	3,640.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,202.70	3,080.50
210204	Ажилгүйдлийн даатгал	768.30	746.90
210205	Эрүүл мэндийн даатгал	7,683.80	7,468.30
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	442,115.30	440,722.40
210301	Гэрэл, цахилгаан	19,515.30	19,509.10
210302	Түлш, халаалт	420,353.60	418,967.80
210303	Цэвэр, бохир ус	2,246.40	2,245.50
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,626.30	16,624.90
210401	Бичиг хэрэг	1,740.20	1,740.00
210402	Тээвэр, шатахуун	11,373.30	11,372.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,512.80	3,512.80
2105	<b>Нормативт зардал</b>	335.30	335.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	335.30	335.30
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,803.80	4,721.10
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	167.00	167.00
210604	Урсгал засвар	4,636.80	4,554.10
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	5,722.70	5,456.70
210702	Дотоод албан томилолт	5,722.70	5,456.70
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,232.20	6,388.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,999.20	6,035.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	330.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	145.00	144.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	30.00	55.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30.00	30.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	475.00	-
210807	Газрын төлбөр	123.00	123.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	76,541.10	56,541.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,191.10	56,191.10

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	350.00	350.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	163,796.30	94,368.40
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	138,112.20	69,531.30
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	138,112.20	69,531.30
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	25,684.10	24,837.10
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,718.20	15,718.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,168.90	8,168.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,797.00	950.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	1,175,028.60	870,627.60
220001	Барилга байгууламж	869,722.50	639,422.10
222001	Тоног төхөөрөмж	102,450.00	101,300.60
223001	Бусад хөрөнгө	202,856.10	129,904.80
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	80,000.00	100.00
230001	Эргэж төлөгдөх зээл	80,000.00	100.00
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,406,420.90	2,213,083.70
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,317,853.70	1,238,157.90
320001	Орон нутгийн төсвөөс	1,087,632.40	1,007,936.60
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	230,221.30	230,221.30
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,088,567.20	974,925.90
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605.00	605.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	614,105.30	974,320.90
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	473,856.90	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	528,494.20
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	863,257.50

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

/мянган.төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>26,263,1</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>26,263,1</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>20,904,5</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>660,8</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	660,8
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20,243,7</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,243,7
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,358,6</b>

2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,358,6
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,358,6
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>26,263,1</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>26,263,1</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,419,4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,020,0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,823,7
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цэцэг сумын Засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн “Орон нутгийн хөгжил дэвшилд манлайлагч байж мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны мэргэшсэн байгууллага байх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон дараах зорилтыг тавин ажилласан байна.Үүнд:

- ✓ Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохин байгуулж хяналт тавих
- ✓ Баг байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах
- ✓ Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохин байгуулах
- ✓ Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохин байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тайлагнах, хяналт тавих
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг
- ✓ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, цахим систем нэвтрүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэх
- ✓ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ,
- ✓ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт орж Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 7/06-р тогтоолоор байгуулагдсан сумын өмч хамгаалах байнгын зөвлөл тус сумын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин хагас жилийн тооллого хийсэн боловч жилийн эцсийн тооллого хийгээгүй, төсвийн хөрөнгөөр болон хандив тусламжаар ирсэн хөрөнгөд ИТХ-ын хуралдаанаар тогтоол гаргуулан өмч хөрөнгийг бүртгэлд тусгуулж, актлах хөрөнгийг шийдвэрийн дагуу устгах ажлыг хариуцан ажиллаагүй хөрөнгөд тавих хяналт сул байна.

Цэцэг сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдсэн байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5058.8 сая төгрөгөөр буюу 60.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Тайлангийн үзүүлэлтүүд	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	794,809.6	993,392.7	(198,583.1) 1.2
Авлага	410,901.4	631,364.5	(220,463.1) 1.5
Бараа материал	230,860.8	50,337.5	180,523.3 0.2
Үндсэн хөрөнгө	12,691,088.7	7,393,773.1	5,297,315.6 0.6
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>14,127,660.5</b>	<b>9,068,867.8</b>	<b>5,058,792.7 0.6</b>
Богино хугацаат өр төлбөр	28,853.3	41,441.7	(12,588.4) 1.4
Цэвэр хөрөнгө, өмч	14,098,807.2	9,032,847.7	5,065,959.5 0.6
Засгийн газрын оруулсан капитал	2,079,824.1	856,592.6	1,223,231.5 0.4
Хуримтлагдсан үр дүн	9,922,513.0	7,935,879.9	1,986,633.1 0.8

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,096,470.2	276,395.3	1,820,074.9	0.1
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>14,127,660.5</b>	<b>9,068,867.8</b>	<b>5,058,792.7</b>	<b>0.6</b>

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө цэвэр өмч хөрөнгийн данснууд байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 794.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 993.4 сая төгрөг болж 198.6 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна. ОНХС-ийн төлөвлөсөн ажлууд он дамжин хэрэгжиж байгаатай холбогдон олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээр өссөн байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 217.8 сая төгрөг болж, өмнөх оноос 105.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	27,721.3	1,588.4	(26,132.9)
Төлбөртэй үйлчилгээний авлага	36,259.7	-	(36,259.7)
Татаас санхүүжилтийн авлага		-	-
Зээлийн хүүгийн авлага	164,194.7	134,520.9	(29,673.8)
Хувь хүмүүсээс авах авлага	95,527.3	81,734.4	(13,792.9)
<b>Дүн</b>	<b>323,703.0</b>	<b>217,843.7</b>	<b>(105,859.3)</b>
<b>АВЛАГЫН НИЙТ ДҮН</b>	<b>323,703.0</b>	<b>217,843.7</b>	<b>(105,859.3)</b>

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ажилчидтай холбоотой авлага 26.1 сая, зээлийн хүүгийн авлага 29.7 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 36.3 сая, хүмүүсээс авах авлага 13.8 сая төгрөгөөр буурч өөрчлөгдсөн байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан хөрөнгийн зардлын эцсийн үлдэгдэл 413.5 сая төгрөг болж өмнөх оноос 326.3 сая төгрөг болж өссөн байна.

Хүснэгт №02 Авлагын үлдэгдэл		/сая.төгрөг/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	87,198.5	413,520.9	326,322.4
<b>Дүн</b>	<b>87,198.5</b>	<b>413,520.9</b>	<b>326,322.4</b>
<b>АВЛАГЫН НИЙТ ДҮН</b>	<b>87,198.5</b>	<b>413,520.9</b>	<b>326,322.4</b>

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардлын авлага нь орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлууд он дамжуулан хэрэгжүүлэх урьдчилж гарсан зардлын авлагатай холбоотой байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 50.4 сая төгрөг болж өмнөх оноос 180.5 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
<b>Түүхий эд материал</b>	129,382.7	15,291.9	114,090.8	0.1
Тусгай зориулалттай материал	6,661.1	2,819.5	3,841.6	0.0
Эм боох материал	71,670.9	12,212.4	59,458.5	0.2
Бэлэн бүтээгдэхүүн	51,050.7	260.0	50,790.7	0.0
<b>Хангамжийн материал</b>	101,478.1	35,045.6	66,432.5	35%
Бичиг хэргийн материал	1,094.9	381.2	713.7	0.3
Аж ахуйн материал	11,775.7	1,380.0	10,395.7	0.1
сэлбэг хэрэгсэл	341.0	-	341.0	0.0
Түлш шатах тослох материал	675.5	-	675.5	0.0
Барилгын засварын материал	1,650.0	-	1,650.0	0.0
Хүнсний материал	18,022.3	55.0	17,967.3	0.0
Бусад хангамжийн материал	67,918.7	33,229.4	34,689.3	0.5
<b>Нийт бараа материал</b>	230,860.8	50,337.5	180,523.3	0.2

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 53.9 сая төгрөгийн худалдан авалт хийж 60.2 сая төгрөгийн материал зарцуулж 174.2 сая төгрөгийн хөрөнгө бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой өөрчлөлт орсон байна.

### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 12691.1 сая төгрөг байсан бол оны эцэст 7393.8 сая төгрөг болж 5297.3 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 433.8 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлого авч, 6422.4 сая төгрөгийн хөрөнгө балансаас баланст шилжүүлж 334.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

### 3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 28.8 сая, эцсийн үлдэгдэл 41.4 сая төгрөг болж 12.6 сая төгрөгөөр буурсан нь байгууллагад өгөх хөрөнгө оруулалтын ажлын дутуу санхүүжилт олгосонтой холбоотой өглөг буурсан байна.

### 3.4.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 2079.8 сая төгрөг байснаас оны эцэст 856.6 сая төгрөг болж 1223.2 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн баланс шилжсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2406.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2406.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Цэцэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04 өдрийн 5/07 тоот тогтоолоор 2406.4 сая төгрөгөөр анх баталж ирснийг сум ИТХ-ын 2022 оны 10 сарын 07-ны 6/13 тогтоолоор 2406.4 сая төгрөгөөр тодотгол хийн баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2406.4 сая төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1007.9 сая, 230.2 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжих, 0.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 974.3 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас, нийт 2213.1 сая төгрөгөөр санхүүжүүлжээ.

*Хүснэгт 5. Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл  
/мянган төгрөгөөр/*

Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,317,853.7	1,238,157.9
Орон нутгийн төсвөөс	1,087,632.4	1,007,936.6
Орон нутгийн хөгжлийн сан	230,221.3	230,221.3
Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих	-	-
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1,088,567.2	974,925.9
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	605.0	605.0
Туслах үйл ажиллагааны орлогоос	614,105.3	974,320.9
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	473,856.9	-
<b>ЭХҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>2,406,420.9</b>	<b>2,213,083.8</b>

*Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант оны гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1087.6 сая, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 230.2 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.6 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 614.1 сая, оны эхний үлдэгдлээс зарцуулах 473.9 сая төгрөг нийт 2406.4 сая төгрөгийг тус тус зарцуулах эрх нээлгэж нийт 2213.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1877.6 сая төгрөгийг зарцуулж 863.2 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс ОНХС-д зарцуулагдаагүй үлдсэн үлдэгдэл 772.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх санд 91.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Аймгийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд 5.5 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1877.6 сая төгрөг буюу 78.0 хувьтай байгаа нь татварын орлогоос аймгийн ерөнхий орлогын дансанд 5.5 сая төгрөг төвлөрүүлж сангийн хөрөнгө зарцуулаагүй дараа онд шилжүүлсэн мөнгөний үлдэгдэлтэй холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6 сая, туслах үйл ажиллагааны орлого 614.1 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6 сая, туслах үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 974.3 сая,

нийт 974.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж туслах үйл ажиллагааны орлого буюу зээлийн эргэн төлөлтийн орлого 360.2 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Хүснэгт 6. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Орлогын ангилал	2022 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	1,295,677.7	1,622,625.6	(326,947.9)
Нийт орлого ба тусламжийн дүн	670,967.4	631,379.7	39,587.7
Татварын орлого	670,967.4	631,379.7	39,587.7
Орлогын албан татвар	200,900.0	256,281.2	(55,381.2)
Хувь хүний орлогын албан татвар	200,900.0	256,281.2	(65,546.40)
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	118,900.0	215,206.1	(96,306.1)
Үйл ажиллагааны орлого	16,300.0	6,012.6	10,287.4
Хөрөнгийн орлого	35,000.0	24,834.9	
Шууд бус орлого	30,700.0	10,227.7	20,472.3
Хөрөнгийн албан татвар	65,876.0	23,132.5	42,743.5
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	13,500.0	1,604.0	11,896.0
Бууны албан татвар	2,376.0	1,151.3	1,224.7
Малын тоо толгойн албан татвар	50,000.0	20,377.2	29,622.8
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	-	-	-
Бусад татвар, телбер, хураамж	404,191.4	351,966.0	52,225.4
Бусад нийтлэг телбер, хураамж	5,700.0	62,444.5	(56,744.5)
Улсын тэмдэгийн хураамж	2,500.0	60,464.5	(57,964.5)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	1,200.0	1,160.0	40.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,000.0	820.0	1,180.0
Газрын телбер	11,671.4	10,853.3	818.1
Газрын телбер	11,671.4	10,853.3	818.1
Дуудлага худалдаа	-	-	-
Байгалийн нөөц ашигласны телбер	386,820.0	278,668.2	108,151.8
Ан амьтны нөөц ашигласны телбер	384,750.0	276,718.2	108,031.8
Ус, рашааны нөөц ашигласны телбер	1,070.0	400.0	670.0
Байгалийн ургамлын нөөц ашигласны телбер	1,000.0	1,550.0	(550.0)
Татварын бус орлого	624,710.3	991,245.9	(366,535.6)
Нийтлэг татварын бус орлого	624,710.3	991,245.9	(366,535.6)
Хувьцааны ногдол ашиг	-	-	-
Торгуулийн орлого	10,000.0	16,320.0	(6,320.0)
Туслах үйл ажиллагааны орлого	614,710.3	974,320.9	(359,610.6)
үндсэн үйл ажиллагааны орлого	605.00	605.00	-

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 1622.6 сая төгрөг орж 326.9 сая төгрөгөөр давж биелсэн байна. Малын хөлийн татвар 29.6 сая, үл хөдлөх хөрөнгийн татвар 11.9 сая, ан амьтны нөөц ашигласны татвар 108.1 сая төгрөгөөр тасарч, цалин хөлс, ашгийн татвар 96.5 сая, хүн амын орлогын албан татвар 65.4 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 8.8 сая, дээд шатны төсөв захирагчаас 1.0 сая, засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй орлогоос 16.4 сая нийт 26.3 сая төгрөгийн орлого орж бараа үйлчилгээний бусад зардалд 26.3 сая төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэцэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Эрдэнэцэцэг 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 03 дугаар сарын 25-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 22-ний өдрийн 1/15 албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 8125.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 81.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал тооцох хувийг 60 хувиар буюу 48.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж 2022 оны санхүүгийн тайлангийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 1933.5 сая төгрөгийн 1 хувь буюу 19.3 сая төгрөгийн төлөвлөлтийн шатанд тогтоосон 60% хувь буюу 11.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төсвөөс үр ашиггүй урсгал зардал санхүүжүүлсэн, ИТХ-ын төлөөлөгч зардал анхан шатны баримт хангалтгүй төсөв зарцуулсан зөрчил илэрсэн тул зөрчлийг таслан зогсоох зөвлөмж өглөө.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, ЗДТГ, ИТХ, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн бөгөөд төсөв өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийн мэдээллийн 12 гүйлгээ хугацаа хоцроон бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аудитаар нийт 261.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 20.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 43.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, 197.9 сая төгрөгийн 4 зөвлөмж өгөгдсөн байгааг 47.8 хувьтай биелүүлсэн ч өмнөх жилүүдийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

*Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/						
	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	20.0			1	20.0	-
Албан шаардлага	1	43.9	1	43.9	-	-	100
Зөвлөмж	4	197.9	3	85.6	1	112.3	43.3
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>261.8</b>	<b>4</b>	<b>129.5</b>	<b>2</b>	<b>132.3</b>	<b>47.8</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэл, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг он оноор хөөж авлагыг тооцоо нийлж баталгаажуулсан байдал, цалингийн санг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8.1 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрсэн тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтын дагуу санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Өвс худалдаж авах мөнгө шилжүүлээд урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй 8.1 сая төгрөгийн залруулга санхүүгийн тайланд хийж сумын нэгтгэлд авлаа.

Аудитаар нийт 452.1 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 20.0 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 226.2 сая төгрөгийн 2 албан шаардлага бичиж, 205.9 сая төгрөгийн 5 зөвлөмж өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

- ✓ *Зураг төсөвт өртөг, ажлын даалгавар, төсвийн гүйцэтгэл байхгүй, өмнөх оны ажлын гүйцэтгэлийн тайлан байхгүй, баталгаат хугацааны барьцаа хөрөнгө суутгаагүй, гэрээний биелэлт дүгнээгүй, ажлын гүйцэтгэлээр санхүүжилт олгоогүй, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, сангийн журам зөрчин урсгал зардалд үр ашиггүй зардал санхүүжүүлсэн 14.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.4-д "нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа, 60.3.2-д улс төр нам, төрийн бус байгууллагын зарлага, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалт*
- ✓ *НДШ дутуу төвлөрүүлсэн 1759.5 мянга, ХАОАТ дутуу төвлөрүүлсэн 782.4 мянган төгрөг нийт 2541.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалт,*
- ✓ *Цалингийн зардлаас ашиг дутуу төвлөрүүлсэн, өглөг авлагын тооцоо хийж баримтжуулаагүй 467.7 мянга, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийсэн, хөрөнгө хугацаандаа нийлүүлээгүй, сургалтын төлбөр илүү төлсөн, шагнал өгсөн эзэн байхгүй, хийсэн ажлын тайлангүй 2.7 сая төгрөг, нийт 3163.7 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалт,*

### 5.2 Албан шаардлага

- ✓ *Анхан шатны баримтын бүрдэл дутуу, жолоочийн тооцоо бодож тооцоо хийгээгүй, нярваас бичгээр олгож байгаа шатахуун, замын хуудсаар баталгаажихгүй зөрүүтэй, өвсний тооцоо болон бусад зардлын тооцоо хийж өр авлагыг баталгаажуулаагүй 40.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалт,*

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- ✓ *Ажлын даалгаврын дагуу хөрөнгө хүлээн авсан актгүй, хөрөнгө нийлүүлээгүй, төрийн хэмнэлтийн хууль хэрэгжүүлээгүй, шууд худалдан авах гэрээ хийсэн, анхан шатны баримт хангалтгүй, хөрөнгийн шинж чанаргүй зардал болон орон нутгийн өмчит газрын урсгал зардлыг санхүүжүүлсэн 120.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.4-д "нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа", 60.3.3-д "үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашин, ёслолын арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалт,*
- ✓ *Зээлийн эргэн төлөлт хангалтгүй, зээлийн үлдэгдэл зөрүүтэй, тооцоо хийж баталгаажуулаагүй, дотоод хяналт сул, насжилт өндөртэй авлага буруулаагүй, зарим зээл зориулалт бус ашиглаж байгаа 64.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.*

### **5.3 Зөвлөмж**

#### **5.3.1 Үйл ажиллагаа, хөрөнгөтэй холбоотой**

Илрүүлэлт: Сангийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим ажлууд хүлээн авсан актгүй, гэрээ хийгээгүй, анхан шатны баримт дутуу, бараа материалд орлого аваагүй шууд зардалд бүртгэсэн шагнал урамшил, тэмцээн уралдаан санхүүжүүлсэн, хөрөнгийн бүртгэлд тавих хяналт сул, хөрөнгийн тооллого хийгээгүй, авлага өглөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй 187.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хийж бүртгэл, тайлагнал, ашиглалтад дотоод хяналт хэрэгжүүлж ажиллах, сангийн хөрөнгийн үр дүнг дээшлүүлэх

#### **5.3.2 Бараа материалтай холбоотой**

Илрүүлэлт: Шатахууны тооцоо хийж замын хуудсаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, эмх цэгцгүй, нярвын тайлан гаргалт хангалтгүй зарлагын баримт засвар ихтэй байгаа 18.5 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэж санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, ажлын хариуцлагыг дээшлүүлэх

#### **5.3.3 Орлого үр дүнтэй холбоотой**

**Илрүүлэлт:** Орлого нэмэгдүүлэх эргэлтийн хөрөнгө, эдийн засгийн шинжилгээ хийж үр ашгийг тооцоогүй авлага өглөгийг баталгаажуулаагүй, дотоод хяналт сул, халаалтын орлого бүрэн тооцоогүй зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Орон нутгийн өмчит газрын үйл ажиллагаанд дотоод хяналт болон нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, ажлын хариуцлагыг дээшлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж	
					Залруулсан			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өвс худалдаж авах мөнгө шилжүүлээд хүлээн аваагүй урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй /авлага бүртгэх/	1	8.1	1	8.1	1	8.1	-	-
Дүн	1	8.1	1	8.1	1	8.1	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зураг төсөвт өртөг, ажлын даалгавар, төсвийн гүйцэтгэл байхгүй, гэрээнд заасан ажлын хөлсөөс илүү санхүүжилт олгосон, өмнөх оны ажлын гүйцэтгэлийн тайлан байхгүй, баталгаат хугацааны барьцаа хөрөнгө суутгаагүй, гэрээний биелэлт дүгнээгүй, ажлын гүйцэтгэлээр санхүүжилт олгоогүй, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, сангийн журам зөрчин урсгал зардалд	1	14,296.1	1	14,296.1			-	-

үр ашиггүй зардал санхүүжүүлсэн								
НДШ дутуу төвлөрүүлсэн 2377.3 мянга, ХАОАТ дутуу төвлөрүүлсэн 782.4 мянга	1	2,541.9	1	2,541.9				
Цалингийн зардлаас ашиг дутуу төвлөрүүлсэн, өглөг авлагын тооцоо хийж баримтжуулаагүй, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийсэн, хөрөнгө хугацаандаа нийлүүлээгүй, сургалтын төлбөр илүү төлсөн, шагнал өгсөн эзэн байхгүй, хийсэн ажлын тайлангүй,	1	3,163.7	1	3,163.7				
Анхан шатны баримтын бүрдэл дутуу, жолоочийн тооцоо бодож тооцоо хийгээгүй, няраваас бичгээр олгож байгаа шатахуун, замын хуудсаар баталгаажихгүй зөрүүтэй, өвсний тооцоо болон бусад зардлын тооцоо хийж өр авлагыг баталгаажуулаагүй,	1	40,828.3			1	40,828.3		
Ажлын даалгаварын дагуу хөрөнгө хүлээн авсан актгүй, ажлын даалгаварын дагуу хөрөнгө нийлүүлээгүй, төрийн хэмнэлтийн хууль хэрэгжүүлээгүй, шууд худалдан гэрээ хийсэн, анхан шатны баримт хангалтгүй, хөрөнгийн шинж чанаргүй зардал болон орон нутгийн өмчит газрын урсгал зардлыг санхүүжүүлсэн, ХХС-ийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй	1	185,315.6			1	185,315.6		
Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, акт дүгнэлтгүй сэлбэг материал худалдан авсан, зарцуулсан баримтгүй, төсвийг үр ашиггүй зарцуулсан,	3	18,566.7					3	18,566.7
Сангийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим ажлууд хүлээн авсан актгүй, гэрээ хийгээгүй, анхан шатны баримт дутуу, бараа материалд орлого аваагүй шууд зардалд бүртгэсэн шагнал урамшил, тэмцээн	1	187,421.4					1	187,421.4

уралдаан санхүүжүүлсэн, хөрөнгийн бүртгэлд тавих хяналт сул, авлага өглөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй								
Орлого нэмэгдүүлэх эргэлтийн хөрөнгө, эдийн засгийн шинжилгээ хийж үр ашгийг тооцоогүй авлага өглөгийг баталгаажуулаагүй, дотоод хяналт сул, халаалтын орлого бүрэн тооцоогүй	1	-					1	
<b>Дүн</b>	10	452,133.7	3	20,001.7	2	226,143.9	5	205,988.1

**Санхүүгийн тайлангийн аудитын илэрсэн нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл**  
/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алдаа зөрчил илэрсэнгүй								
Дүн								

**ХОВД АЙМАГ ДАХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**